



DEFENSE RESEARCH
INSTITUTE OF MONGOLIA

Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.01.003>

Trends in United Nations Peace Operations and Mongolia's Participation

Tuvdendarjaa Munkh-Orgil¹, Buni Namjilsuren²

¹Colonel, Ph.D, Associate Professor, Director, Defense Research Institute of Mongolia

E-mail address: munkh-orgil@mids.gov.mn, ORCID: 0009-0001-9907-0011

²Researcher, International peace support studies center, Defense Research Institute of Mongolia

E-mail address: namjilsuren@mids.gov.mn, ORCID: 0009-0007-8820-5244

Received: 13 February 2026

Revised: 15 March 2026

Accepted: 21 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

In the contemporary international security environment, the nature of armed conflict has undergone profound transformation. Internal, multi-actor, and protracted conflicts have become increasingly prevalent, while geopolitical competition among major powers has intensified and intersected in specific regions. These developments have placed the traditional model of United Nations (UN) peace operations under significant strain, raising fundamental questions regarding their effectiveness and operational viability.

This article examines the theoretical foundations, core characteristics, and limitations of traditional UN peace operations, and systematically analyzes emerging models that have evolved in response to changes in the international security environment. These include region-led peace operations, hybrid missions, and light-footprint approaches, assessed from both theoretical and practical perspectives. Drawing on regional case studies and empirical examples, the article further explores how these new models have been implemented in practice. Against this background, it evaluates Mongolia's policy and strategic orientation toward participation in UN peace operations, highlighting the implications of ongoing transformations for national engagement. The article concludes by emphasizing the policy significance of reorienting Mongolia's peacekeeping participation toward a quality-driven, specialized, and flexible approach.

Keywords: United Nations, peace operations, emerging trends, multipolar order, Mongolia

НҮБ-ын энхийн ажиллагааны чиг хандлага ба Монгол Улсын оролцоо

Түвдэндаржаа Мөнх-Оргил¹, Бунь Намжилсүрэн²

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор,
хурандаа, munkh-orgil@mids.gov.mn, ORCID: 0009-0001-9907-0011

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Энхийг дэмжих олон улсын судалгааны
төвийн Эрдэм шинжилгээний ажилтан, namjilsuren@mids.gov.mn, ORCID: 0009-0007-8820-5244

ХУРААНГУЙ:

Өнгөрсөн түүхэн цаг хугацаанд олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийн ажиллагаа нь хамтын аюулгүй байдлыг хангах гол механизм болж ирсэн боловч XXI зуунд зэвсэгт мөргөлдөөний шинж чанар өөрчлөгдөхөөс гадна гадаад, дотоод, олон оролцогчтой, төрийн бус субъект давамгайлсан хэлбэрт шилжиж, их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн эрчимжсэн нь энхийн ажиллагааны институцийн чадавх, ялангуяа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр гаргах үйл явцад бодит хязгаарлалт үүсгэж байна. Үүний улмаас энхийн ажиллагааны уламжлалт цэрэг төвтэй загвар нь улс төрийн тогтвортой байдлыг хангах чадамжийн хувьд хангалтгүй болох нь тодорхой болж байна.

Энэхүү нөхцөл байдалд энхийн ажиллагаа нь олон хэмжээст, улс төр-институц төвтэй шинж чанартай болж ирэхийг хамгаалах, улс төрийн зуучлал, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, аюулгүй байдлын салбарын шинэчлэл, төрийн институцийн чадавхыг хөгжүүлэх зэрэг өргөтгөсөн чиг үүргийг хэрэгжүүлэх боллоо. Үүний зэрэгцээ бүс нутгийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж, НҮБ болон бүс нутгийн байгууллагын хамтарсан “холимог” ажиллагаа, мөн тусгай улс төрийн ажиллагаанд суурилсан уян хатан оролцооны хэлбэрүүд давамгайлах хандлага ажиглагдаж байна. Энэ нь энхийн ажиллагааны үр нөлөөг цэргийн оролцооноос илүүтэйгээр улс төрийн зохицуулалтын чанар, институцийн уялдаа, олон талт хамтын ажиллагааны түвшинээр тодорхойлох шинэ парадигмыг бий болгож байна.

Ийм нөхцөлд Монгол Улс энхийн ажиллагаанд оролцох бодлогоо олон талт байдлаар хангах, өөр өөр түвшний оролцоонд чиглүүлэн өргөжүүлэх нь чухал юм.

Түлхүүр үг: Нэгдсэн Үндэстний Байгууллага, энхийн ажиллагаа, шинэ чиг хандлага, олон туйлт тогтолцоо, Монгол Улс

Удиртгал

Дэлхийн II дайны дараах олон улсын аюулгүй байдлын институцийн тогтолцоонд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын энхийн ажиллагаа нь хамтын аюулгүй байдлыг хангах гол механизмын нэг болон төлөвшсөн бөгөөд олон улсын эрх зүйд суурилсан дэг журмыг бодит нөхцөлд хэрэгжүүлэх институцийн чухал хэрэгсэл байсаар ирсэн. НҮБ-ын Дүрэмд тусгагдсан хүч хэрэглэхийг хориглох, маргааныг энхийн замаар зохицуулах зарчмууд нь энхийн ажиллагааны онолын суурь болж, улс хоорондын мөргөлдөөний дараах тогтвортой байдлыг хадгалах практик механизмыг бүрдүүлсэн (*United Nations, 1945*). Судлаачид энхийн ажиллагааг олон улсын эрх зүйд суурилсан дэг журмыг хэрэгжүүлэх “зөөлөн институцийн хэрэгсэл” гэж тодорхойлсон нь түүний эрх зүйт шинж, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тайлбарлан тодорхойлж байсан (*Bellamy, Williams & Griffin, 2010*).

НҮБ-ын уламжлалт энхийн ажиллагаа нь талуудын зөвшөөрөл (consent), төвийг сахих байдал (impartiality), хүч хэрэглэхгүй байх (non-use of force) гэсэн үндсэн гурван зарчимд суурилан гал зогсоох хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, мөргөлдөөний дахин сэдэрлтийг зогсооход чиглэж ирсэн. Энэхүү загвар нь Дэлхийн II дайны дараах үед улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн давамгайлж, талуудын хооронд тодорхой түвшний улс төрийн зөвшилцөл бүрдсэн нөхцөлд харьцангуй үр нөлөөтэй хэрэгжиж байв. Ийм орчинд энхийн ажиллагаа нь ажиглалт, хяналт, зуучлалын хязгаарлагдмал чиг үүрэгтэй, энхийг сахиулах цэргийн ажиллагнаад тулгуурласан байдлаар энх тайвныг хадгалах бодит механизм болж чадсан юм (*Bellamy et al. 2010*).

Гэсэн хэдий ч уламжлалт энхийн ажиллагаа нь төр төвтэй тоглогчид тулгуурлаж ирсэн нь олон талын ашиг сонирхолтой оролцогчтой шинэ үеийн мөргөлдөөнийг зохицуулах боломжгүй болж эхэлсэн. Мөн талуудын “зөвшөөрөл”

нь бодит утгаараа тогтворгүй, хэсэгчилсэн шинжтэй болж, энхийн ажиллагаанд оролцогч хүчин нь аль нэг талын ашиг сонирхлыг хамгаалж байна гэх хардлагаас үүдэн төвийг сахих байдалд нь эргэлзэх тохиолдол нилээдгүй байсан. Үүний улмаас энхийн ажиллагаанд баримтлах дүрэм журам, зарчим, болон бодит нөлөө үзүүлэх хүлээлтийн хоорондын зөрчилд орж үр дүн, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдалд сөргөөр нөлөөлөх болсон байна (*United Nations 2020*).

Мөн хүч хэрэглэхгүй байх зарчим нь иргэдийг хамгаалах, хүчирхийллийг таслан зогсоох шаардлагатай нөхцөлд хангалтгүй болж, энхийн ажиллагааны бодит чадавх, итгэлцэлд сөргөөр нөлөөлөх тохиолдол цөөнгүй гарч байна. Ийм нөхцөлд энхийн ажиллагаа нь зэвсэгт хүчирхийллийг хянах бус, харин түүний үр дагаврыг ажиглах түвшинд хязгаарлагдах эрсдэлтэй байсан нь Босни, Руанда зэрэг түүхэн жишээнүүдээр тодорхой харагддаг (*Bellamy et al. 2010*).

XXI зуунд олон улсын аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлтүүд нь энэхүү уламжлалт загварын онол, практикийн суурийг сорьж байна. Орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний дийлэнх нь үл танигдах олон талт аюул, эрсдлийн шинжтэй, хэд хэдэн оролцогчтой, дэвшилтэт техник, технологи, зэвсэгтэй ажиллагаа давамгайлсан хэлбэрт шилжиж, энгийн иргэдэд учруулах хохирол нэмэгдсэн нь энхийн ажиллагааны зорилго, арга хэрэгслийг дахин тодорхойлох шаардлагыг бий болгож байна (*Fortna, 2008*). Үүний зэрэгцээ их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн эрчимжиж НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр гаргах үйл явцыг сааруулж, хамтын аюулгүй байдлын механизмын үр нөлөөг хязгаарлаж буйг судалгаанууд онцолж байна (*United Nations, 2023*).

Эдгээр өөрчлөлтүүд нь энхийн ажиллагааг уламжлалт “гал зогсоох, ажиглах” чиг үүргээс давж, иргэдийг хамгаалах (Protection of Civilians), улс төрийн зуучлал, хууль дээдлэх ёс, аюулгүй байдлын салбарын шинэчлэл, төрийн институцийн чадавх бэхжүүлэх зэрэг олон хэмжээст үүрэгтэй болсон (*Bellamy & Hunt, 2015*). Гэсэн хэдий ч энэхүү үүргийн өргөжилт нь улс төрийн зөвшилцөл, санхүүжилт, нөөцийн хязгаарлалтаас шалтгаалан хэрэгжилтийн зөрчил дагуулж байгаа бөгөөд энэ нь энхийн ажиллагааны үр нөлөөг бууруулах эрсдэлтэйг НҮБ-ын тайлангууд тэмдэглэж байна (*United Nations, 2018; 2020*).

Үүнтэй зэрэгцэн бүс нутгийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж, НҮБ болон бүс нутгийн байгууллагын хамтарсан “холимог” ажиллагаа, мөн тусгай улс төрийн ажиллагаанд (Special Political Missions) суурилсан уян хатан оролцооны хэлбэрүүд хөгжиж байна. Судлаачид энэхүү өөрчлөлтийг энхийн ажиллагааны “институцийн дасан зохицол” хэмээн тодорхойлж, үр дүнг нь цэргийн хүчин чадлаар бус улс төрийн зохицуулалт, институцийн уялдаа, тухайн бүс нутаг болон орон нутгийн оролцоогоор хэмжих шинэ хандлага бий болж буйг онцолжээ (*Williams, 2018*).

Гэхдээ энхийн ажиллагааны хэлбэр, онцлог нь бүс нутаг бүрт ялгаатай байхаар байна. Тухайлбал Европт их гүрнүүдийн шууд оролцооноос шалтгаалан энхийн ажиллагааны цэрэгжсэн хэлбэр хэрэгжих боломж хязгаарлагдаж, институцийн болон эрх зүйн үүрэг давамгайлж байгаа бол Ойрх Дорнодод олон талт геополитикийн өрсөлдөөн нь улс төрийн зуучлалын үүргийг тэргүүнд тавьж байна. Харин Африк тивд бүс нутгийн байгууллагуудтай хамтарсан, энхийг бүтээн байгуулах урт хугацааны загварууд илүү хөгжиж байгаа нь энхийн ажиллагааны

олон хэлбэрт, нөхцөлд суурилсан шинжийг тод илэрхийлж байна (Bellamy et al., 2010; Williams, 2018).

Иймээс НҮБ-ын уламжлалт энхийн ажиллагааны загвар нь тодорхой түүхэн нөхцөлд үргээ амжилттай гүйцэтгэж байсан ч өнөөгийн олон оролцогчтой, улс төрийн зөвшилцөл сул, өндөр эрсдэлтэй мөргөлдөөнүүдийн орчинд дангаар хангалттай шийдэл болж чадахгүй нь илэрхий болж байна. Энэ бодит байдал нь НҮБ-ын энхийн ажиллагааг илүү уян хатан, улс төрийн шийдэлд төвлөрсөн байдлыг халж олон түвшний шинэ загварууд руу шилжих зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Орчин үеийн нөхцөл дэх энхийн ажиллагааны шинэ чиг хандлага

Сүүлийн арван жилд олон улсын аюулгүй байдлын орчинд гарч буй бүтэц, шинж чанарын өөрчлөлтүүд нь НҮБ-ын энхийн ажиллагааны уламжлалт ойлголт, хэрэгжилтийн хүрээг үндсээр нь өөрчлөхөд хүргэж байна. Өмнө нь хяналт, ажиглалт, гал зогсоох хэлэлцээрийн хэрэгжилтийг баталгаажуулахад төвлөрч байсан энхийн ажиллагаа нь өнөөдөр иргэдийг хамгаалах (Protection of Civilians – POC), улс төрийн зуучлал, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, аюулгүй байдлын салбарын шинэчлэл (Security Sector Reform – SSR), төрийн институтийн чадавхыг хөгжүүлэх зэрэг олон хэмжээст, цогц шинжтэй үүрэг гүйцэтгэх болсон байна. Энэ өөрчлөлт нь орчин үеийн зэвсэгт мөргөлдөөнүүдийн дийлэнх нь гадаад, дотоод аюул занал, эрсдлийн шинжтэй, олон тоглогч, оролцогчтой болж, энгийн иргэд мөргөлдөөний гол хохирогч болж буй бодит нөхцөлтэй шууд холбоотой (Bellamy & Hunt, 2015).

Гэвч энхийн ажиллагааны мандат ийнхүү өргөжин тэлэхийн хэрээр түүнийг хэрэгжүүлэх улс төрийн болон материаллаг нөөцийн суурь харьцангуй сулрах хандлага ажиглагдаж байна. Ялангуяа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн түвшинд байнгын гишүүн орнуудын стратегийн ашиг сонирхлын зөрчил гүнзгийрч, энхийн ажиллагаа эхлүүлэх, сунгах, эсхүл өргөтгөх асуудлаар тогтвортой улс төрийн зөвшилцөл бүрдэх нь улам бүр хүндрэх болсон (United Nations, 2023). Үүний улмаас өргөн хүрээтэй, “том хэмжээний” энхийн ажиллагаанууд санхүүжилт, хүний нөөц, улс төрийн дэмжлэгийн хувьд тогтворгүй байдалд орж, НҮБ-ыг илүү уян хатан, нөхцөлд суурилсан, өртөг багатай загваруудыг эрэлхийлэхэд хүрч байна.

Энэхүү өөрчлөлтийн хүрээнд тодорч буй нэг гол чиг хандлага нь бүс нутгийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж буй явдал юм. Ялангуяа Африкт Африкийн Холбоо болон дэд бүсийн байгууллагууд ажиллагааны газар оронд цагийн байдлыг тогтворжуулах эхний, өндөр эрсдэлтэй үе шатыг хариуцаж, харин НҮБ нь улс төрийн зохицуулалт, энхийн бүтээн байгуулалт, институтийн сэргээн босголтын урт хугацааны үүргийг гүйцэтгэх нь улам бүр түгээмэл болж байна (Williams, 2018). Энэ нь бүс нутгийн болон орон нутгийн давамгайлах оролцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ НҮБ-ын институцийн болон нөөцийн хязгаарлалтыг нөхөх бодит механизм болж байна.

Үүнтэй зэрэгцэн НҮБ болон бүс нутгийн байгууллагуудын хамтарсан “холимог” (hybrid) энхийн ажиллагааны загварууд хөгжиж байна. Эдгээр нь НҮБ-ын олон улсын эрх зүйн байдал, улс төрийн зуучлах чадавхыг бүс нутгийн байгууллагын ажиллагааны нөлөөлөх чадвар, хурдтай шийдвэр гаргах боломжтой

хослуулахыг зорьдог (Bellamy et al., 2010a). Гэсэн хэдий ч ийм загварууд нь удирдлага болон хариуцлагын тогтолцоо, санхүүжилтийн зохицуулалт зэрэг олон төвөгтэй асуудлыг дагуулсаар байгаа нь практик хэрэгжилтийн гол сорилт хэвээр байна.

Нөгөө талаас, сүүлийн жилүүдэд тусгай улс төрийн ажиллагаа (Special Political Missions – SPM)-д суурилсан оролцооны хэлбэр эрчимтэй нэмэгдэж байна. Эдгээр ажиллагаа нь өргөн цар хүрээтэй цэргийн хүчний оролцоогүйгээр улс төрийн зуучлал, итгэлцэл сэргээх, хүний эрхийн мониторинг хийх, институтийн чадавх бэхжүүлэхэд төвлөрдөг бөгөөд улс төрийн зөвшилцөл сул, аюулгүй байдлын эрсдэл өндөр орчинд НҮБ-ын оролцоог хадгалах уян хатан механизм болж байна (*United Nations, 2020*). Энэ нь энхийн ажиллагаа заавал цэргийн оролцоогоор тодорхойлогдох албагүй, харин улс төрийн магадгүй эдийн засгийн нөлөөлөх үйл ажиллагааг тасралтгүй байдлыг хангах замаар бодит үр нөлөө үзүүлэх боломжтойг нотолж байна.

Иймээс орчин үеийн энхийн ажиллагааны хөгжлийн ерөнхий чиг хандлага нь уламжлалт хандлагаас татгалзаж, мөргөлдөөний онцлог, бүс нутгийн нөхцөл байдал, улс төрийн боломж, оролцогч талуудын чадавхын онцлогт тулгуурласан ялгавартай, уян хатан, олон түвшний оролцооны “архитектур” руу шилжиж байгаагаар тодорхойлогдож байна. Энэ шилжилт нь энхийн ажиллагааны үр дүн, эрх зүйт байдлыг цэргийн оролцооны хэмжээ, хүчний бүтэц бус, харин улс төрийн зохицуулалтын үр дүн, институц хоорондын уялдаа, олон талт түншлэлийн харилцааны чанараар тодорхойлох хандлагыг улам бүр гүнзгийрүүлж байна.

Энэ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийн ажиллагаа нь орчин үеийн олон улсын тогтолцооны өөрчлөлтөд дасан зохицохын тулд “цэрэг төвтэй” ойлголтоос “улс төр–институц төвтэй” цогц механизм руу шилжиж байгааг харуулж энхийн ажиллагааны ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж байна.

Зарим бүс нутаг дах энхийн ажиллагаанд гарч буй онцлог

Орчин үеийн олон улсын аюулгүй байдлын орчинд дасан зохицох гэж хичээж буй НҮБ-ын энхийн ажиллагаа нь улс төр, геополитикийн бодлого, үйл ажиллагаанаас хамаарч харицан адилгүй ялгаатай хэлбэрээр өөрчлөгдөж байгааг Европ, Ойрх Дорнод, Африк гэсэн гурван бүс нутгийн жишээн дээр авч үзлээ.

Нэг. Европын бүс нутаг дах Их гүрнүүдийн сөргөлдөөн ба институцийн хязгаарлалт. Европын бүс нутагт, ялангуяа Орос-Украины дайны нөхцөл байдал нь НҮБ-ын уламжлалт энхийг сахиулах ажиллагаа хэрэгжих институцийн орон зай үндсэндээ хязгаарлагдсаныг тод харуулж байна. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн улс шууд оролцож буй өндөр эрчимтэй зэвсэгт мөргөлдөөнд улс төрийн зөвшилцөл бүрдэх боломж бараг үгүй болж, энхийн ажиллагаанд шаардлагатай мандат батлах, аюулгүй байдлын баталгаа хангах нөхцөл бүрдэхгүй байна.

Ийм нөхцөлд НҮБ-ын оролцоо нь цэргийн ажиллагаанд бус, харин:

- гал зогсоох болон энхийн хэлэлцээний дипломат сувгийг хадгалах,
- хүний эрхийн зөрчил, дайны гэмт хэргийг баримтжуулах,
- энгийн иргэд, дүрвэгсдийн хамгаалалтыг дэмжих зэрэг институцийн болон эрх зүйн чиг үүрэгт төвлөрч байна. Энэ нь Европ дахь энхийн ажиллагаа

нь “энхийг сахиулах” peacekeeping)-аас “олон улсын эрх зүйн дэг журмыг хамгаалах” институцийн механизм руу шилжиж буйг харуулж байна. Цаашид тус бүс нутагт НҮБ-ын үүрэг нь мөргөлдөөнийг шууд зогсоохоос илүүтэйгээр дайны дараах улс төрийн тогтвортой байдал, хариуцлагын тогтолцоо олон улсын эрх зүйн хэрэгжилтийг хангах урт хугацааны оролцоонд чиглэх төлөвтэй байна.

Хоёр. Ойрх Дорнод дах олон талт геополитик ба зуучлалын төвлөрөл. Ойрх Дорнодын бүс нутагт Сирийн иргэний дайн, Израиль-Палестины мөргөлдөөн, Йемений иргэний дайн зэрэг олон төвт, урт хугацааны зөрчилдөөнүүд нь НҮБ-ын стандарт, нэг загварын энхийн ажиллагаа хэрэгжих боломж хязгаарлагдмал болохыг харуулж байна. Эдгээр мөргөлдөөнд бүс нутгийн болон дэлхийн томоохон тоглогчид давхар оролцож, дотоод зөрчилдөөн нь олон улсын шинжтэй болж хувирсан нь энхийн ажиллагааны уламжлалт байдлыг сулруулж байна.

Ийм нөхцөлд НҮБ нь:

- олон талт улс төрийн зуучлалын үндсэн платформ,
- хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохицуулах институц,
- гал зогсоох түр зохицуулалтыг дэмжих механизм болон хувирч байна. Өөрөөр хэлбэл,
- энхийн ажиллагааны үр нөлөө нь цэргийн оролцооны цар хүрээнээс илүүтэйгээр улс төрийн процессын тасралтгүй байдлыг хадгалах чадвараар тодорхойлогдож байна.

Цаашид Ойрх Дорнод дахь НҮБ-ын үүрэг нь мөргөлдөөнийг богино хугацаанд шийдвэрлэхээс илүүтэйгээр:

- мөргөлдөөний өргөжилтийг хязгаарлах,
- олон талт хэлэлцээний орчныг хадгалах,
- геополитикийн тоглогчдыг нэг институцийн хүрээнд барьж тогтоох стратегийн “тогтворжуулагч” механизмын үүргийг гүйцэтгэх шинжтэй байх хандлагатай байна.

Гурав. Африк тив дэх Бүс нутгийн байгууллагуудтай хамтарсан загварын институцжилт. Африкт Мали, Судан, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс зэрэг жишээнүүд нь НҮБ-ын энхийн ажиллагаа бүс нутгийн байгууллагуудтай нягт уялдах шаардлагыг бодитоор харуулж байна. Ялангуяа Африкийн Холбоо болон дэд бүсийн байгууллагууд (ECOWAS, IGAD зэрэг) нь мөргөлдөөний эхний, өндөр эрсдэлтэй үе шатанд аюулгүй байдлыг хангах, цэргийн ажиллагааг эхлүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна.

Харин НҮБ нь дараагийн шатанд:

- улс төрийн шилжилтийг дэмжих,
- энхийг бүтээн байгуулах, бэхжүүлэх,
- төрийн институц, засаглалын чадавхыг сэргээх урт хугацааны үүргийг гүйцэтгэх хандлага давамгайлж байна. Энэ нь “дараалсан болон хамтарсан ажиллагааны загвар”-аар институцжиж байгааг илтгэнэ.

Африк дахь энхийн ажиллагааны үр дүнг:

- аюулгүй байдлын богино хугацааны тогтвортой байдлаас гадна

- засаглалын тогтвортой байдал,
- нийгмийн эвлэрэл,
- хууль дээдлэх ёс,
- институтийн бэхжилт зэрэг олон хэмжигдэхүүнээр үнэлэх шаардлага бий болж байна.

Иймээс тус бүс нутагт энхийн ажиллагаа нь уламжлалт “энхийг сахиулах”-аас “энхийг бүтээн байгуулах” цогц, урт хугацааны процесс руу шилжиж байна.

Дээрх харьцуулсан шинжилгээнээс үзэхэд НҮБ-ын энхийн ажиллагаа нь тогсон нэг загвараар хэрэгжих боломж улам бүр хумигдаж, бүс нутгийн онцлог, геополитикийн нөхцөл, институцийн чадавхад тулгуурласан олон хэлбэрт, уян хатан тогтолцоо болон хувирч байна. Тухайлбал, Европт институцийн хязгаарлалт, эрх зүйн чиг үүрэг давамгайлж, Ойрх Дорнодод улс төрийн зуучлал, процесс хадгалах үүрэг төвлөрч, Африкт бүс нутгийн байгууллагатай хамтарсан, энхийг бүтээн байгуулах урт хугацааны загвар хэлбэрээр бэхжиж байна.

Энэ нь энхийн ажиллагааны ирээдүй нь цэргийн оролцоонд бус, харин улс төрийн зохицуулалт, институцийн уялдаа, бүс нутгийн хамтын ажиллагаа болон тухайн улс орон, бүс нутагт улс төр, эдийн засгийн нөлөөлөл өндөртэй улс орнуудын ашиг сонирхолд тулгуурлах шинжтэй болж байна.

Монгол Улсын энхийн ажиллагаанд оролцох бодлогын чиг хандлага

Монгол Улс нь НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцохдоо төвийг сахисан, хариуцлагатай, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тулгуурласан байр суурийг тууштай баримталж ирсэн бөгөөд энэхүү оролцоо нь тус улсын гадаад бодлогын “энхийг эрхэмлэсэн” үзэл баримтлал, “гуравдагч хөрш”-ийн бодлогын бодит хэрэгжилтийн нэг чухал илэрхийлэл болсоор байна. Энхийн ажиллагаанд тогтвортой, идэвхтэй оролцох нь Монгол Улсын хувьд олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд хариуцлагатай оролцогч улсын статусаа бэхжүүлэх, улмаар гадаад бодлогын олон тулгуурт тэнцвэрийг хадгалах стратегийн ач холбогдолтой хэмээн судлаачид үздэг (*United Nations, 2020*).

Орчин үеийн энхийн ажиллагааны шинж чанар, чиг хандлага гүнзгий өөрчлөгдөж буй нөхцөлд Монгол Улсын оролцооны бодлого нь цэрэг хандивлах уламжлалт хандлагаас гадна, илүү мэргэшсэн баг, бүлэг болон өндөр ур чадвартай, шийдвэр гаргах түвшин дэх алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэх шаардлагатай болж байна. Тухайлбал, оператив болон тактикийн түвшинд штабын офицер, цэргийн ажиглагч, инженер, эмнэлгийн нэгж, сургалт болон чадавх бэхжүүлэх чиглэлийн мэргэжилтнүүдийг системтэйгээр бэлтгэн оролцуулахын зэрэгцээ НҮБ-ын төв болон бүс нутгийн байгууллагын түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргалтад оролцох албан тушаалд Монгол Улсын төлөөллийг нэмэгдүүлэх нь стратегийн өндөр ач холбогдолтой. Ийнхүү шийдвэрт нөлөөлөх, шийдвэр гаргах түвшний албан тушаалд суурилсан оролцоог бэхжүүлэх нь зөвхөн энхийн ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхээс гадна Монгол Улсын гадаад бодлогын зорилтуудтай уялдсан, илүү бодит өгөөж бүхий оролцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

Түүнчлэн энхийн ажиллагаанд бүс нутгийн байгууллага тэргүүлсэн, эсхүл НҮБ болон бүс нутгийн байгууллагын хамтарсан “холимог” хэлбэрүүд рүү шилжиж буй

өнөөгийн нөхцөлд Монгол Улс уян хатан, олон талт оролцооны чадавхыг хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд цэргийн оролцоог дангаар нь чухалчлахаас илүүтэйгээр тусгай улс төрийн ажиллагаа, энхийн ажиллагааны бэлтгэл, хамтарсан сургалт, институтийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, мөн энхийн ажиллагааны чиглэлээр бодлогын судалгаа, шинжилгээний чадавхыг хөгжүүлэн манлайлах байр суурийг бэхжүүлэх нь стратегийн хувьд оновчтой юм. Энэ нь энхийн ажиллагаанд оролцогч улс орнуудын үүрэг улам бүр өргөжиж, улс төрийн зохицуулалт, институтийн тогтвортой байдлыг дэмжихэд чиглэж буй орчин үеийн чиг хандлагатай нийцэж бидний хувьд давуу байдлыг бий болгоно гэж үзэж байна.

Үүнээс гадна энхийн ажиллагаанд хуримтлуулсан туршлага дээр суурилсан сургалт, судалгааны институцийн чадавхыг бэхжүүлэх нь Монгол Улсын урт хугацааны стратегийн зорилтын нэг байх шаардлагатай. НҮБ болон түнш орнуудтай хамтарсан судалгаа, сургалтын хөтөлбөр, дадлага, чадавх бэхжүүлэх механизмийг тогтмолжуулах замаар Монгол Улсыг энхийн ажиллагаанд “мэргэшсэн түнш улс” болгон төлөвшүүлэх бодит боломж бүрдэнэ. Ийм институцчилсан хөгжил нь зөвхөн олон улсад нэр хүндийг өсгөхөөс гадна үндэсний батлан хамгаалах болон хүний нөөцийн чадавхыг давхар бэхжүүлэх олон талын үр өгөөжтэй.

Иймд Монгол Улсын энхийн ажиллагаанд оролцох стратегийн чиг баримжаа нь олон туйлт, тогтворгүй олон улсын орчинд төвийг сахисан байр сууриа хадгалах, мэргэшилд суурилсан, уян хатан, олон түвшний оролцоог хөгжүүлэхэд чиглэх нь зүйтэй. Энхийн ажиллагааг гадаад бодлого, батлан хамгаалах бодлогын “зөөлөн хүч”-ний чухал бүрэлдэхүүн хэсэг болгон ашиглах замаар Монгол Улс олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэх, үндэсний ашиг сонирхлоо хамгаалах, олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоогоо өргөжүүлэх стратегийн боломжийг илүү үр ашигтайгаар хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

НҮБ-ын энхийн ажиллагаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд Дэлхийн II дайн-ы дараах олон улсын аюулгүй байдлын тогтолцооны тулгуур механизмын нэг байсаар ирсэн хэдий ч орчин үеийн аюулгүй байдлын орчны гүнзгий, олон талт өөрчлөлтийн нөлөөгөөр уламжлалт загварынхаа хүрээнд дангаар үр нөлөө үзүүлэх боломж хязгаарлагдаж буй нь энэхүү судалгааны дүнгээр нотлогдож байна. Ялангуяа гадаад, дотоод тоглогчтой аюул занал, эрсдлийн шинжтэй олон оролцогч бүхий зэвсэгт мөргөлдөөн давамгайлах, мөн их гүрнүүдийн ашиг сонирхолд тулгуурласан геополитикийн өрсөлдөөн эрчимжиж буй өнөөгийн нөхцөлд энхийн ажиллагаа нь цэрэг, техникийн оролцооноос илүүтэй улс төрийн шийдэлд тулгуурласан, бодит прагматик нөхцөлд суурилсан, олон түвшний зохион байгуулалт бүхий шинэ хэлбэрүүд рүү шилжих зайлшгүй шаардлагатай тулгарч байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд бүс нутгийн байгууллага тэргүүлсэн, НҮБ болон бүс нутгийн байгууллагын хамтарсан “холимог” (hybrid) ажиллагаа, мөн тусгай улс төрийн ажиллагаанд (special political missions) суурилсан загварууд нь энхийн ажиллагааны хууль, эрх зүйт байдал, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх чадвар, институц хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааны уян хатан байдлыг

хадгалах чадамжийг харьцангуй өндөр түвшинд хангаж байна. Түүнчлэн улс төрийн зөвшилцөл сул, тогтворгүй орчинд ч тодорхой түвшний оролцоог тасралтгүй үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлж байгаагаараа эдгээр загварууд онцлогтой. Иймд энхийн ажиллагааны үр нөлөөг цэргийн оролцооны цар хүрээ, хүчин чадлаар бус харин улс төрийн зохицуулалтын чанар, институцийн уялдаа, бүс нутгийн түншлэлийн гүнзгийрэл зэрэг олон хүчин зүйлсийн нэгдмэл байдлаар тодорхойлох хандлагыг бий болгож байна.

Өнөөгийн НҮБ-ын энхийн ажиллагааны хувьсан өөрчлөгдөж буй чиг хандлага нь их гүрнүүдийн ашиг сонирхолоос үүдэлтэй олон улсын аюулгүй байдлын тогтолцооны өөрчлөлттэй шууд холбоотой. Энэхүү чиг хандлагын өөрчлөлт нь Монгол Улсын хувьд НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцох бодлого, стратегийн чиг баримжаагаа шинэ нөхцөлд нийцүүлэн дахин тодорхойлох бодит боломжийг бүрдүүлж байна. Тодруулбал, Монгол Улс нь цэргийн багийн оролцооноос гадна мэргэшсэн баг, бүлгийг оролцоог нэмэгдүүлэх, чадавхид тулгуурласан шийдвэрт нөлөөлөх, шийдвэр гаргах түвшний албан тушаалтны оролцоог өргөжүүлэх, түүнчлэн уян хатан, нөхцөлд дасан зохицох чадвартай шинэ загваруудад идэвхтэй нийцэх замаар олон улсын энхийн ажиллагаанд үзүүлэх бодит хувь нэмрээ нэмэгдүүлэх стратегийн давуу талтай юм. Энэ нь манай улсын төвийг сахисан гадаад бодлого болон өөрийн боломжит нөөцөд тулгуурласан хүчийг олон улсад таниулах, Монгол Улсын энхийн сахиулах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх зэрэгт чухал ач холбогдолтой.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Bellamy, Alex J., Paul D. Williams, and Stuart Griffin. 2010. *Understanding Peacekeeping*. 2nd ed. Polity.
2. Burges, Sean W. 2015. “Brazil’s Africa Strategy: Role Conception and the Drive for International Status. By Christina Stolte.” *International Affairs* 91 (5): 1212–14. <https://doi.org/10.1111/1468-2346.12442>.
3. Fortna, Virginia Page. 2008. *Does Peacekeeping Work? Shaping Belligerents’ Choices after Civil War*. Princeton University Press.
4. United Nations. 1945. “Charter of the United Nations.” United Nations. <https://www.un.org/en/about-us/un-charter>.
5. United Nations. 2020. “The Future of Peace Operations.” United Nations Department of Peace Operations. <https://peacekeeping.un.org>.
6. United Nations. 2023. “A New Agenda for Peace.” United Nations. <https://peacekeeping.un.org>.